



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/86

Баянхутаг сум

АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.3, Аймгийн засаг даргын 2025 оны 03 сарын 18-ны өдрийн А/142 тоот захирамжыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумыг хөгжүүлэх үндсэн чиглэл, байгаль орчны хамгааллыг харгалзан шинэлэг аргачлалаар боловсруулан сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хяналт мониторинг хийх, үр дүнг олон нийтэд тайлагнах үүрэг бүхийн ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүнд уялдсан холбогдох үйл ажиллагааны зардлыг байгалийн нөөц ашигласны төлбөр, малын тоо толгойн албан татвар гэх зэрэг бусад боломжит эх үүсвэрээс орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх саналыг боловсруулан сумын Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

3. Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулан холбогдох арга хэмжээний зардлыг дараа оны орон нутгийн төсөвт тусгах саналыг боловсруулж сумын Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.


4. Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хяналт мониторинг хийж үр дүнг улирал бүр багийн Иргэдийн Нийтийн Хурал, олон нийтэд танилцуулж байхыг ажлын хэсгийн гишүүдэд даалгасугай.

ДАРГА

Д.БАЙГАЛМАА



Баянхутаг сумын Засаг даргын
2025 оны 07 дугаар сарын 08 өдрийн А/36
тоот захирамжийн нэгдүгээр хавсралт



Ажлын хэсгийн ахлагч:

Нарийн бичгийн дарга:

Гишүүдэд:

Сумын засаг даргын орлогч

Газрын даамал

Санхүү албаны дарга

Байгаль орчны улсын байцаагч

Хүнс, хөдөө аж ахуйн мэргэжилтэн

Мал эмнэлгийн улсын байцаагч

Жаргалант багийн Засаг дарга

Улаан-Өндөр багийн Засаг дарга

Цантын хоолой багийн Засаг дарга

Баянхутаг сумын Засаг даргын
2025 оны 04 дугаар сарын 08 өдрийн А/36
тоот захирамжийн хоёрдугаар хавсралт

**СУМЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТҮҮНД ХЯНАЛТ-МОНИТОРИНГ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Нэг: Зорилго

Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний уялдааг хангах хэрэгжилтэнд хяналт мониторинг хийх

1.1. Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр хэлэцэн байгаль орчин, газрыг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг жил бүрээр төлөвлөж холбогдох байгууддага, мэргэжилтний гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах, хэрэгжилтэнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх.

1.2. Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан газрын доройтлыг бууруулах, уур амьсгалын сөрчлөлт, биологийн олон янзын байдлыг харгалзан арга хэмжээнүүдийг нийгмийн бүлгүүдийн тэгш оролцоог хангах замаар хэрэгжүүлэх.

1.3. Жил бүрийн бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний салшгүй бүрдэл байдлаар боловсруулах түүний хэрэгжилтэд хяналт мониторинг хийх.

Хоёр: Ажлын зохион байгуулал, чиглэл

2.1. Ажлын хэсэг улиралд 1 удаа батлагдсан хуваарь, төлөвлөгөөний дагуу хуралдаж, үүрэг даалгаврын биелэлтийг хэлцөх, санал солилцох, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар холбогдох албан тушаалтанд хүргүүлэх.

2.2. Ажлын хэсгийн гишүүдээс гарсан саналыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нэгтгэн хурлын тэмдэглэл хөтөлж, ажлын хэсгийн даргаар баталгаажуулан сумын Засаг даргад танилцуулсаны дагуу хамтын шийдэл бүхий санал, зөвлөмж гаргах.

Гурав: Үр дүнг танилцуулах

Ажлын хэсэг сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, ажлын хэсгийн хийсэн ажлын байланг улирал бүр сумын иргэд, олон нийтэд хурал, цуглаан, уулзалт, хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэг бүх төрлийн арга хэлбэрээр танилцуулах.